

**МУБИС-ийн СӨБС-ийн
“ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ” эрдэм шинжилгээний сэтгүүл
эрхлэн гаргах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар МУБИС-ийн СӨБС /цаашид “сургууль” гэх/ – ийн “ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ” сэтгүүл /цаашид “сэтгүүл” гэх/ -ийг эрхлэн гаргахтай холбоотой аливаа харилцааг зохицуулна.
- 1.2. Журам нь “МУБИС-ийн Хөгжийн бодлого 2014-2024”, “Оюуны өмчийн талаар баримтлах бодлого”, “МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүн сургуулиас эрхлэн гаргах журам” болон олон улсын стандартад нийцсэн байна.
- 1.3. Сэтгүүл нь бага насны боловсролын эрдэм шинжилгээ, судалгааны улирал тутмын хэвлэл байх бөгөөд монгол хэлээр “Хүүхдийн хөгжил”, англи хэлээр “Child Development” гэсэн нэртэй байна.
- 1.4. Сэтгүүлийн үүсгэн байгуулагч нь сургууль бөгөөд сэтгүүлийн нэрийг эзэмших эрх үүсгэн байгуулагчид хадгалагдана.
- 1.5. Сэтгүүл нь сургуулийн өмч бөгөөд олон улсын стандартын цуврал дугаартай байх буюу ISSN (international Standard Serial Number)¹ бүртгэлээр баталгаажсан байна.
- 1.6. Сэтгүүл нь сургуулийн эрдэм шинжилгээний цахим шуудангийн хаяг дээр байна. Сэтгүүл нь цахим сүлжээнд хуудастай байж болно. Сэтгүүлийн албан ёсны хаяг нь сургуулийн хаяг байна.

Хоёр. Нийтлэлийн бодлого

- 2.1. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь МУБИС-ийн профессор багш нар болон бага насны хүүхдийн хөгжил, боловсролын салбарын эрдэмтэн судлаач, суралцагчдын шинжлэх ухааны мэдлэг, чадвар, сэтгэлгээг хөгжүүлэх, судалгаа шинжилгээний ажлын туршлага, ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.
- 2.2. Сэтгүүлд хэвлэгдэх бүтээлийн агуулга бага насны хүүхдийн хөгжил, боловсролын салбарын тулгамдсан асуудлын хүрээнд тодорхой асуудлыг орчин үеийн онол, аргазүйн түвшинд судалсан СӨБС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлээр бичигдсэн байна.
- 2.3. Сэтгүүл нь зорилго чиглэлээ тодорхойлсон ойрын болон алсын хараа, эрхэм зорилготой байна. Ойрын зорилго нь (JOL)² цахим хувилбартай болох ба 5 жилийн дотор шилдэг өгүүллийн дугаарыг англи хэл дээр хэвлэдэг болсон байна.
- 2.4. Сэтгүүл нь нийтлүүлэхээр ирүүлсэн өгүүлэл тус бүрд хянан магадлагаа (англиар Peer Review) хийх бөгөөд хянан магадлагааг хараат бусаар хийж, үр дүнг зохиогчид тодорхой мэдээлнэ.

¹ “Хүүхдийн хөгжил” сэтгүүл (ISSN 2960-2270)

² JOL – Journal online

- 2.5. Сэтгүүлийн хянан магадлагаа нь өгүүллийн зохиогч болон хянан магадлагч сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүний аль аль тал нь нэгнээ мэдэх боломжгүй (англиар Double-blind peer review) байна.
- 2.6. Сэтгүүлд нийтэлсэн өгүүлэл нь зохиогчийн оюуны өмч байна.
- 2.7. Зохиогч өгүүллээ нийтлүүлэхээр ирүүлснээр өгүүллийг нийтлэх, нийтэд түгээх эрхийг сэтгүүлд олгохыг зөвшөөрсөн гэж ойлгоно.
- 2.8. Өгүүлэлд тавигдах шаардлагыг Сэтгүүлийн удирдамжид зааснаар баримтална.

Гурав. Редакцийн зөвлөл

- 3.1. Сэтгүүлийн редакцийг сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, Захирлын тушаалаар батална.
- 3.2. Редакц нь эрхлэгч, нарийн бичиг, 6 гишүүнтэй байна. Гишүүд нь салбартаа нэр хүнд бүхий гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид байна.
- 3.3. Редакцид МУБИС-ийн захирлын 2018 оны 12 сарын 10-ны өдрийн А/313 тоот тушаалаар баталсан журмын дагуу магистрантыг туслах ажилтнаар авч ажиллуулж болно.

Дөрөв. Хянан тохиолдуулах үйл ажиллагаа

- 4.1. Бүтээлийг сэтгүүлийн ээлжит дугаар гарахаас 45 хоногийн өмнө сургуулийн эрдэм шинжилгээний цахим хаяг болох eceresearch@msue.edu.mn хаягаар хүлээн авна. Өгүүлэл хүлээн авснаас хойш 2-3 долоо хоногийн дотор бүтээлийг уншиж, шүүмж өгнө.
- 4.2. Сэтгүүлийн хянан магадалгаа хийх үйл ажиллагаанд МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүн сургуулиас эрхлэн гаргах журам”-ын 4-р зүйлийг дагаж мөрдөнө.

Тав. Зохиогчийн эрх ба ёс зүй

- 5.1. Сэтгүүлд өгүүллээ хэвлүүлж буй зохиогч нь МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүн сургуулиас эрхлэн гаргах журам”-ын 6-р зүйлийг дагаж мөрдөнө.

Зургаа. Сэтгүүлийн хэвлэлт ба санхүүжилт

- 6.1. Сэтгүүлийг монгол хэлээр эрхлэн гаргах ба улирал тутмын хэвлэл байна.
- 6.2. Сэтгүүл нь МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүн сургуулиас эрхлэн гаргах журам”-ын 8.1-д заасны дагуу сургууль хариуцна.

Долоо. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах

- 7.1. Сэтгүүлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг эрхлэн гаргаж буй сэтгүүлийн редакц хариуцах ба нэмэлт, өөрчлөлтийг сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.